ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дорнод аймгийн Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан.

**Аудитын код:** ДОА-2024/01/НА-СТА-ТЕЗ


Цахим хуудас: www.audit.mn

Чойбалсан хот

2024 он

Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
Тэргүүлэх аудитор: Б.Болортуул
Утас: 7058-4203, Цахим хаяг: bolortuulb@audit.gov.mn

Аудитын менежер: И.Сэмжидмаа
Утас: 7058-4204, Цахим хаяг: semjidmaai@audit.gov.mn
Ахлах аудитор: Д.Нармандах
Утас: 7058-4207, Цахим хаяг: narmandakhd@audit.gov.mn
Аудитор: Б.Одхүү
Утас: 7058-4207, Цахим хаяг: odkhuub@audit.gov.mn
Аудитор: Б.Оюунхэрлэн
Утас: 7058-4207, Цахим хаяг: ouynkherlenb@audit.gov.mn


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## АГУУЛГА


1. Хараат бус аудиторын дүгнэлт ..........
2. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл ..........
3. Санхүүгийн тайлангийн тодруулга ..........
   3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа ..........
   3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин ..........
   3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал ..........
   3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт ..........
4. Аудитын тайлан ..........
   4.1 Ерөнхий зүйл ..........
   4.2 Материаллаг байдал ..........
   4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт ..........
   4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ..........
   4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт ..........
   4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал ..........
5. Аудитын илрүүлэлт ..........
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл ..........


**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ИТХ | Иргэдийн Төлөөлөгчдийн хурал |
| ОНӨААТҮГ | Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар |
| ОНӨҮГ | Орон нутгийн өмчит газар |
| ОНХС | Орон нутгийн хөгжлийн сан |
| НА | Нийцлийн аудит |
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| СТА | Санхүүгийн тайлангийн аудит |
| ТЕЗ | Төсвийн ерөнхийлөн захирагч |

## 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

7 дугаар баг, Хэрлэн сум, Дорнод аймаг, 21000
ЗДТГ-ын II байр, Утас/Факс: 7058-4203

2024.04.22 № 340

танай ____________-ны №_____________-т

ДОРНОД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА
М.БАДАМСҮРЭН ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.4-д заасны дагуу Дорнод аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дорнод аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Байгууллага үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй байна.

**Аудитын гол асуудал**

Монгол Улсын Засгийн газар, Азийн хөгжлийн банкны хооронд байгуулсан зээлийн гэрээний дагуу “Орон нутгийн хотуудын нийтийн аж ахуй хөгжлийн хоёрдугаар үе шатны төсөл” МОН1907-ийн хүрээнд авсан зээлийн 1,858.3 сая төгрөгийг төвлөрүүлэн өр төлбөрийн үлдэгдлийг бууруулсан байна.

**Бусад асуудлын хэсэг**

Дорнод аймгийн ИТХ-ын 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн 17/01 дугээр тогтоолоор “Буйр нуурын экосистемийг хамгаалах, аялал жуулчлал хөгжүүлэх төв” ОНӨҮГ байгуулагдсан байна

Төсвийн ерөнхийлөн захирагч нь санхүүгийн нэгтгэсэн тайланг Сангийн яамны төсвийн ерөнхийлөн захирагчийн багцын “Э-тайлан” цахим системд тайлагнасан байна.

011021230

Дорнод аймгийн 2023 оны хөгжлийн жилийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн 19/10 дугаар тогтоолоор хангалттай гэж дүгнэсэн байна.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Б.БОЛОРТУУЛ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

/мянган төгрөгөөр/

| Код: | Тайлангийн үзүүлэлт | 2022 оны 12-р сарын 31 | 2023 оны 12-р сарын 31 |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **22,157,401.1** | **28,165,116.2** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | **12,429,365.5** | **17,525,963.9** |
| 33 | АВЛАГА | 4,021,428.7 | 4,477,650.1 |
| 35 | БАРАА МАТЕРИАЛ | 5,641,341.6 | 6,030,695.2 |
| 36 | НӨӨЦИЙН БАРАА | 65,265.4 | 130,807.0 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **106,839,825.3** | **140,614,429.6** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | **106,839,825.3** | **140,614,429.6** |
| 39200 | Биет хөрөнгө | 100,661,518.3 | 128,847,877.1 |
| 39300 | Биет бус хөрөнгө | 6,178,307.0 | 11,766,552.5 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **128,997,226.4** | **168,779,545.8** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **3,770,962.3** | **2,230,912.3** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | **2,155,428.3** | **2,230,912.3** |
| 41300 | Өглөг | 2,155,428.3 | 2,230,912.3 |
| **42** | **УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | **1,615,534.0** | 0.0 |
| 42200 | Урт хугацаат зээл | 1,615,534.0 | 0.0 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **125,226,264.0** | **166,548,633.5** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | **125,226,264.0** | **166,548,633.5** |
| 51100 | Засгийн газрын оруулсан капитал | 28,061,608.2 | 33,423,303.4 |
| 51106 | Эздийн өмчийн бусад хэсэг /ТӨҮГ/ | 9,121,071.7 | 10,951,159.3 |
| **51200** | **Хуримтлагдсан үр дүн** | **80,329,471.7** | **114,476,530.2** |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 7,714,112.4 | 7,697,640.6 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **128,997,226.4** | **168,779,545.8** |

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

/мянган төгрөгөөр/

| Код: | Тайлангийн үзүүлэлт | 2022оны 12-р сарын 31 | 2023 оны 12-р сарын 31 |
|---|---|---|---|
| I | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I) | **108,123,628.9** | **149,828,531.1** |
| 11 | ТАТВАРЫН ОРЛОГО | **34,494,919.7** | **53,010,171.8** |
| **110** | **Орлогын албан татвар** | **26,293,490.8** | **35,287,798.2** |
| 1100 | Хувь хүний орлогын албан татвар | 18,443,498.2 | 25,696,095.9 |
| 1101 | Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт | -896,404.2 | -1,037,144.5 |
| 1103 | ААН-ын орлогын албан татвар | 8,746,396.9 | 10,628,846.8 |
| 113 | Хөрөнгийн албан татвар | 2,693,606.5 | 4,410,313.9 |
| 118 | Бусад татвар, төлбөр, хураамж | 5,507,822.4 | 13,312,059.6 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | **55,947,432.9** | **86,129,400.5** |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 36,479,185.9 | 60,459,344.4 |
| 121 | Хөрөнгийн орлого | 73,380.3 | 219,528.2 |
| 122 | Тусламжийн орлого | 4,448,400.0 | 5,069,870.5 |
| 123 | Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг | 14,946,466.7 | 20,380,657.5 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | **17,681,276.2** | **10,688,958.8** |
| II | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН | **52,868,343.6** | **75,734,232.0** |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | **52,868,343.6** | **75,734,232.0** |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | **49,223,808.9** | **69,830,907.9** |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 10,080,782.5 | 12,897,585.1 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 1,259,744.5 | 1,619,367.3 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 3,492,928.2 | 1,491,686.0 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 1,299,377.8 | 1,826,513.6 |
| 2105 | Нормативт зардал | 1,369,123.9 | 1,392,023.5 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 911,931.6 | 1,301,483.2 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 282,861.2 | 325,907.2 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 9,256,670.7 | 16,316,680.8 |

| | | | |
|---|---|---|---|
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **21,270,388.5** | **32,659,661.1** |
| 211 | ХҮҮ | 1,795,691.2 | 1,858,364.6 |
| 212 | ТАТААС | 309,000.0 | 0.0 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 1,539,843.5 | 4,044,959.5 |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 0.0 | 0.0 |
| III | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II) | 55,255,285.2 | 74,094,299.1 |
| IV | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН | 0.0 | 0.0 |
| **V** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | **168,851,201.6** | **41,875,060.4** |
| **VI** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)** | **-113,595,916.3** | **32,219,238.7** |

## 2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/мянган төгрөгөөр/

| Код: | Тайлангийн үзүүлэлт | Засгийн газрын хувь оролцооний нийт дүн | Нийт цэвэр хөрөнгө/өмч |
|---|---|---|---|
| **1** | **2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **233,949,605.7** | **233,949,605.7** |
| 2 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | -3,446,630.6 | -3,446,630.6 |
| 3 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 230,502,975.1 | 230,502,975.1 |
| 5 | Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт | 8,319,205.3 | 8,319,205.3 |
| 9 | Тайлант үеийн үр дүн | -113,595,916.3 | -113,595,916.3 |
| **10** | **2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **125,226,264.0** | **125,226,264.0** |
| **11** | **2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | **125,226,264.0** | **125,226,264.0** |
| 12 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 1,927,819.8 | 1,927,819.8 |
| **13** | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **127,154,083.9** | **127,154,083.9** |
| 14 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт | -16,471.8 | -16,471.8 |
| 15 | Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт | 7,191,782.8 | 7,191,782.8 |
| 19 | Тайлант үеийн үр дүн | 32,219,238.7 | 32,219,238.7 |
| **20** | **2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **166,548,633.5** | **166,548,633.5** |

## 2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

/мянган төгрөгөөр/

| Код: | Тайлангийн үзүүлэлт | 2022 оны 12-р сарын 31 | 2023 оны 12-р сарын 31 |
|---|---|---|---|
| **I** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)** | **87,103,111.5** | **106,320,676.1** |
| **11** | **ТАТВАРЫН ОРЛОГО** | **34,494,919.7** | **53,010,171.8** |
| 110 | Орлогын албан татвар | 26,293,490.8 | 35,287,798.2 |
| 1100 | Хувь хүний орлогын албан татвар | 18,443,498.2 | 25,696,095.9 |
| 1101 | Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт | -896,404.2 | -1,037,144.5 |
| 1103 | ААН-ын орлогын албан татвар | 8,746,396.9 | 10,628,846.8 |
| 113 | Хөрөнгийн албан татвар | 2,693,606.5 | 4,410,313.9 |
| 118 | Бусад татвар, төлбөр, хураамж | 5,507,822.4 | 13,312,059.6 |
| 1180 | Бусад нийтлэг төлбөр, хураамж | 632,283.0 | 2,120,244.1 |
| 1181 | Газрын төлбөр | 1,620,506.3 | 5,221,458.2 |
| 1182 | Байгалийн нөөц ашигласны төлбөр | 3,255,033.1 | 5,970,357.3 |
| 1183 | Бусад татвар | 0.0 | 0.0 |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **34,310,032.7** | **42,765,418.0** |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 14,841,785.6 | 17,077,361.8 |
| 121 | Хөрөнгийн орлого | 73,380.3 | 219,528.2 |
| 122 | Тусламжийн орлого | 4,448,400.0 | 5,069,870.5 |
| 123 | Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг | 14,946,466.7 | 20,398,657.5 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **18,298,159.1** | **10,545,086.4** |

| | | | |
|---|---|---|---|
| II | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **48,115,907.8** | **58,475,366.4** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **48,115,907.8** | **58,475,366.4** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **44,469,351.7** | **52,506,461.4** |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 12,014,680.1 | 15,189,907.0 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 1,832,468.2 | 2,231,364.5 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 3,925,739.6 | 1,543,534.2 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 3,861,061.5 | 3,233,542.6 |
| 2105 | Нормативт зардал | 1,309,726.2 | 1,347,126.1 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 878,391.3 | 557,410.1 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 282,861.2 | 325,830.5 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 6,834,680.7 | 12,359,125.4 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 13,529,743.0 | 15,718,620.8 |
| 211 | ХҮҮ | 1,795,691.2 | 1,858,364.6 |
| 212 | ТАТААС | 309,000.0 | 64,000.0 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 1,541,864.9 | 4,046,540.4 |
| III | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)** | **38,987,203.8** | **47,845,309.7** |
| IV | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (IV)** | **0.0** | **0.0** |
| V | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)** | **41,337,427.9** | **41,516,011.3** |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 41,337,427.9 | 41,516,011.3 |
| 2200 | Дотоод эх үүсвэрээр | 41,337,427.9 | 41,516,011.3 |
| 2260 | Гадаад эх үүсвэрээр | 0.0 | 0.0 |
| VI | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)** | **-41,337,427.9** | **-41,516,011.3** |
| VII | **САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН** | **-1,112,514.1** | **-1,232,700.0** |
| 14 | Бусад эх үүсвэр | 135.9 | 0.0 |
| 23 | ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ | 812,650.0 | 1,096,700.0 |
| **25** | **САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ** | **300,000.0** | **136,000.0** |
| VIII | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)** | **-3,462,738.3** | **5,096,598.4** |
| 101 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 15,892,103.8 | 12,429,365.5 |
| 20 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 12,429,365.5 | 17,525,963.9 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/мянган төгрөгөөр/

| Тайлангийн үзүүлэлт | Төлөвлөгөө | Төсвийн гүйцэттэлийн тайлан |
|---|---|---|
| **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **88,613,114.4** | **77,330,541.4** |
| **УРСГАЛ ЗАРДАЛ** | **42,643,095.3** | **39,637,599.9** |
| **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **37,045,260.2** | **34,176,912.4** |
| Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 11,433,775.1 | 11,233,167.6 |
| Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 1,439,477.50 | 1,392,413.4 |
| Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 5,473,661.50 | 5,089,471.8 |
| Хангамж, бараа материалын зардал | 781,976.3 | 751,766.7 |
| Нормативт зардал | 128,418.4 | 127,217.0 |
| Эд хогшил, урсгал засварын зардал | 524,053.3 | 518,976.8 |
| Томилолт, зочны зардал | 308,816.5 | 290,206.9 |
| Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 4,482,985.5 | 3,961,145.1 |
| Бараа үйлчилгээний бусад зардал | 12,472,096.10 | 10,812,547.0 |
| **ХҮҮ** | **1,858,364.6** | **1,858,364.6** |
| **ТАТААС** | **64,000.0** | **64,000.0** |
| Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас | 64,000.0 | 64,000.0 |
| **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **3,675,470.50** | **3,538,323.0** |
| Засгийн газрын урсгал шилжүүлэг | 3,081,751.10 | 3,081,751.1 |
| Бусад урсгал шилжүүлэг | 593,719.4 | 456,571.9 |

| | | |
|---|---|---|
| **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **44,171,398.0** | **36,596,241.5** |
| **ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ** | **1,798,621.1** | **1,096,700.0** |
| **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **88,613,114.4** | **79,621,985.7** |
| **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | | **0.0** |
| **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | **75,346,581.6** | **69,944,771.3** |
| **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | **7,933,732.8** | **4,607,343.9** |
| **ТУСЛАМЖИЙН ЭХ ҮҮСВЭРЭЭС САНХҮҮЖИХ** | **5,332,800.0** | **5,069,870.5** |
| Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 0.0 | 4,178,823.1 |
| Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 0.0 | 6,469,396.7 |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/мянган төгрөгөөр/

| Тайлангийн үзүүлэлт | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|
| **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **6,430,064.3** |
| **УРСГАЛЗАРДАЛ** | **6,021,434.3** |
| **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **5,386,373.7** |
| Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 140,267.0 |
| Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 2,312.7 |
| Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 10,175.9 |
| Хангамж, бараа материалын зардал | 116,689.6 |
| Нормативт зардал | 2,006.2 |
| Эд хогшил, урсгал засварын зардал | 22,096.2 |
| Томилолт, зочны зардал | 20,361.6 |
| Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 940,225.0 |
| Бараа үйлчилгээний бусад зардал | 4,132,239.6 |
| **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **635,060.6** |
| Бусад урсгал шилжүүлэг | 489,250.0 |
| Олгосон санхүүжилт, шилжүүлэг | 145,810.60 |
| **ХӨРӨНГИЙНЗАРДАЛ** | **408,630.0** |
| Дотоод эх үүсвэрээр | 408,630.0 |
| **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **6,430,064.3** |
| Нэмэлт санхүүжилтийн орлого | 6,430,064.3 |

## 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 643.7 сая төгрөгийн 7 зөрчил[1] илэрснээс, 2.3 сая төгрөгийн 2 албан шаардлага хүргүүлж, 641.4 сая төгрөгийн 5 зөвлөмж өгсөн.

Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас аймагт олгох шилжүүлэг 1,118.9 сая төгрөгөөр дутуу ирсэн асуудлыг Сангийн яамны санхүүгийн нэгтгэсэн тайланд тусгуулах саналыг ҮАГ-ын СНАГ-т хүргүүлэх.

### 3.1 Албан шаардлага

*Санхүүгийн тайлагналтай холбоотой асуудал.*

1. Гадаад улсад орон нутгийн захиргааны байгууллагатай танилцаж, сайн туршлага судлах үйл ажиллагааны удирдамжийн шаардлагад нийцэхгүй төрийн үйлчилгээний албан хаагчийг оролцуулан онгоцны билетийн төлбөрт 2.3 сая төгрөгийг зарцуулсан байна. /МУ-ын орон нутгийн засаг захиргааны удирдах албан тушаалтан хамрагдах, ЗГ хариуцах бичигтэй/ Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” гэж заасныг зөрчсөн, санхүүгийн тайлангийн нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

2. Өмнөх аудитаар өгсөн 11.0 сая төгрөгийн авлагыг бүрэн барагдуулан ажиллаагүй байна.

### 3.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

*Санхүүгийн тайлагналтай холбоотой асуудал*

1. *Илрүүлэлт*: Хөдөө аж ахуйн сангийн дансанд 2014 оноос эхлэн олгосон 2017 онд дуусах, хугацаа хэтэрсэн 38.6 сая төгрөгийн авлагын үлдэгдэлтэй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, 14 дүгээр зүйлийн 14.2.3-д “өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах” гэж заасныг хэрэгжүүлэн ажиллаагүй байна.

   *Өгсөн зөвлөмж*: Хугацаа хэтэрсэн 2014 оноос үүссэн авлагыг бүрэн барагдуулах.

*Нийцлийн аудит болон бусад хууль тогтоомжтой холбоотой асуудал*

2. *Илрүүлэлт:* Төсвийн ерөнхийлөн захирагчийн хамрах хүрээний дараах байгууллагууд нь Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор санхүүгийн сахилга батыг мөрдөж, ил тод байдлыг хангах, үр ашгийг нэмэгдүүлэх, үрэлгэн байдлыг хязгаарлах бодлогыг баримтлан ажиллаагүй нийт 2,886.8 сая төгрөгийн 31 зөрчил илэрсэн.

   *Өгсөн зөвлөмж:* Хамрах хүрээний байгууллагад хэрэгжүүлэх дотоод хяналтыг сайжруулах.

3. *Илрүүлэлт:* Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хийсэн хяналт, шалгалтаар Төсвийн ерөнхийлөн захирагчийн хамрах хүрээний 18 байгууллагад 1,551.8 сая төгрөгийн 18 зөрчил илэрсэн. Шилэн дансны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2-д "Энэ хуулийн 3.1.1-д заасан төсвийн байгууллага, албан тушаалтны шилэн дансны үйл ажиллагаанд тавих дотоод хяналтыг Төсвийн тухай хуулийн 69 дүгээр зүйлд заасны дагуу төсвийн ерөнхийлөн захирагч хэрэгжүүлнэ" гэж заасан байна.

   *Өгсөн зөвлөмж:* Шилэн дансны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2-д заасны дагуу дотоод хяналтыг хэрэгжүүлэх.

[1] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

1. *Илрүүлэлт:* Аймгийн Орон нутгийн өмчийн газар нь үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон 2.7 сая төгрөгийн нэмэлт орлогыг зарцуулалтын эрх нээх шийдвэргүй зарцуулсан, Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 6 дугаар хавсралтаар батлагдсан "Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчдад орон нутгийн нэмэгдэл олгох тухай журмын 4-т "Орон нутагт ажилласны нэмэгдлийг захиргааны албан тушаал эрхэлдэг орон нутгийн захиргааны байгууллагын төрийн албан хаагчид албан тушаалын сарын үндсэн цалингийн 20 хувиар бодож орон нутгийн болон улсын төсвөөс сар бүр олгоно." гэсэн заалтыг зөрчин аймгийн ЗДТГ 56.5 сая төгрөг, Матад сумын ЗДТГ 16.6 сая төгрөгийн орон нутгийн нэмэгдлийг тус тус олгосон байна.

   *Өгсөн зөвлөмж*: Хамрах хүрээний байгууллагад санхүүгийн оновчтой удирдлагаар ханган, зөвлөн туслах үйлчилгээг үр дүнтэй зохион байгуулж, дотоод хяналтыг сайжруулах.

2. *Илрүүлэлт:* Уул уурхайн тусгай зөвшөөрөл эзэмшигч 11 ААН-ээс гэрээний дагуу авах 602.8 сая төгрөгийн мөнгөн дэмжлэгийг бүрэн авч ажиллаагүй байна.

   *Өгсөн зөвлөмж*: Уул уурхайн тусгай зөвшөөрөл эзэмшигч ААН-тэй байгуулсан гэрээг дүгнэн хэрэгжилтийг хангуулж ажиллах.

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д заасны дагуу "Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ". Харин зөвлөмжийн биелэлтийг 2024 оны 10 дугаар сарын 20 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

| Байгууллагын нэр | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Дорнод аймгийн Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайлан | 3 | 40.9 | - | 0.0 | 2 | 2.3 | 1 | 38.6 | - | - | | |
| **Нийт дүн** | 3 | 40.9 | - | **0.0** | 2 | 2.3 | 1 | 38.6 | - | - | **0** | **0** |

### Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/сая төгрөгөөр/

| Байгууллагын нэр | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| **Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил** | | | | | | | | |
| Дорнод аймгийн Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайлан | 1 | - | | | | | 1 | - |
| **Дүн** | **1** | **0.0** | **-** | **0.0** | **-** | **0.0** | **1** | **0.0** |
| **Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил** | | | | | | | | |
| Дорнод аймгийн Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайлан | 1 | - | | | | | 1 | - |
| **Дүн** | **1** | **0.0** | **-** | **0.0** | **-** | **0.0** | **1** | **0.0** |
| **Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил** | | | | | | | | |
| Дорнод аймгийн Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайлан | 2 | 602.8 | | | | | 2 | 602.8 |
| **Дүн** | **2** | **602.8** | **-** | **0.0** | **-** | **0.0** | **2** | **602.8** |
| **Нийт дүн** | **4** | **602.8** | **-** | **0.0** | **-** | **0.0** | **4** | **602.8** |